



Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр

Аймгийн хөгжлийн чиг баримжаа

Монгол улс

Барилга, хот байгууллагын яам


Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Азийн хөгжлийн банк & Ядуурлыг бууруулах Японы Сан

АХБ ТА 9666-MON төслийн санхүүжилтээр бэлтгэв.



Аймгийн хөгжлийн чиг баримжаа
Өмнөговь аймгийн атлас



Энэхүү атлас нь Аймгийн хөгжлийн чиг баримжаа (АХЧБ) баримт бичгийн хураангуй хувилбар болно.

Монгол улс
Барилга, хот байгууллагын яам
Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы сан
АХБ ТА 9666-MON төслийн санхүүжилтээр бэлтгэв.

Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр


Өмнөговь аймгийн Атлас

2022 оны 2 дугаар сар

Өмнөговь аймгийн хөгжлийн чиг баримжаа (АХЧБ)


groupe huit
Développement urbain

 **MAD** **URBAN** 
naomis
Systèmes d'information



БАЙГАЛЬ ОРЧИН


УС

Усны нөөц (сая м3/ жил)



УУР АМЬСГАЛ

Жилийн дундаж хур тунадас (мм/жил)



ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ



Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн

%26,6

нь тусгай хамгаалалттай газар нутаг (2020)



VS




Монгол улсын нутаг дэвсгэрийн

13,5%


нь тусгай хамгаалалттай газар нутаг (2020)



БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН ДОРОЙТОЛ




- Хязгаарлагдмал усны нөөц.
- Байгалийн 3 бүс, бүслүүрийг дамнан оршдог: аймгийн нутаг дэвсгэрийн 82,5% нь цөл, 17% нь заримдаг цөл, 0,5% нь тал хээрийн бүсэд оршдог.
- Эх газрын эрс тэс уур амьсгалтай, урт өвөл, богино, халуун зунтай. Хур тунадас бага ордог, хуурай уур амьсгалтай.
- Аймгийн хэмжээнд газрын доройтол, цөлжилт эрчимтэй явагдаж байна.
- Дархан цаазат газар 2, байгалийн цогцолборт газар 2, байгалийн нөөц газар 1 бий.




ЭДИЙН ЗАСАГ

ДНБ-ийн дэлгэрэнгүй бүтэц



- Улсын ДНБ-ийн 2 хувийг бүрдүүлж, 21 аймгаас 4 дүгээрт ордог.
- Аймгийн эдийн засгийн үндэс нь уул уурхай ба хөдөө аж ахуй.
- Уул уурхайн салбарын гүйцэтгэл маш өндөр боловч уул уурхайн компаниудын дийлэнх нь нийслэл Улаанбаатар хот эсвэл БНХАУ-д бүртгэлтэй, аймгийн эдийн засгийн гүйцэтгэлд тооцогддоггүй.
- Санхүү, аялал жуулчлал, барилга, тээвэр ба харилцаа, холбоо зэрэг салбарын эдийн засгийн гүйцэтгэл өсөж, цаашид улам хөгжих боломжтой.

Хөдөлмөр эрхлэлт



Хөдөлмөр эрхлэлт хөдөө аж ахуй (35,7%), уул уурхай (14,8%), бөөний ба жижиглэнгийн худалдаа (12,8%), төрийн захиргаа (7,5%), боловсрол (6,6%), боловсруулах үйлдвэрлэл (6,1%)-ийн салбарт төвлөрч байна.

Эдийн засгийн үйл ажиллагаа

Өмнөговь аймаг улсын нийт ДНБ-ийн 2,0 хувийг бүрдүүлж, аймгууд дунд 4 дүгээрт ордог. Хэдийгээр тус аймгийн өрсөлдөх чадвар уул уурхайн салбарт хэсэгчлэн суурилж буй боловч уул уурхайн бүс ДНБ-ээр авч үзвэл аймгууд дунд мөн л 6 дугаарт орж байна. Томоохон нутаг дэвсгэртэй аймаг атал эдийн засгийн үр дүн харьцангуй сул, уул уурхайн бүс эдийн засгийн үйл ажиллагааны эрчмээр аймгууд дунд сүүлээсээ 2 дугаарт орж байна.

Хөгжлийн үндсэн чиг баримжаа



Үндсэн салбар: Мал аж ахуй бол хамгийн чухал салбар (хөдөлмөр эрхлэлтийн 35,7%) ба бэлчээр, усны нөөцийн менежментийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай. Газар тариалангийн үйлдвэрлэл маш бага. Цаашид боловсруулах үйлдвэр, агро-паркийг хөгжүүлэх, МАА-н менежмент, хүнсний ногооны үйлдвэрлэлийг сайжруулах нь хөгжлийн үндэс болно.







Уул уурхайн салбар: Энэ салбарын үйлдвэрлэлийн бүтээмж өндөр (аймгийн ДНБ-ийн 30% орчим), цаашид өргөжин тэлэх боломжтой, эрдэс баялгийн арвин их нөөцтэй, хилийн боомтууд руу төмөр зам барих төлөвлөгөөтэй. Орон нутгийн эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын үзүүлэх нөлөөг бэхжүүлэх шаардлагатай. Хууль, тогтоомжийн хүрээг сайжруулах замаар тус салбарын тогтвортой байдлыг хангах нь зүйтэй.



Үйлчилгээний салбар: Аялал жуулчлалын салбар улам хөгжиж буй, төлөвлөлтийн чадавх сайтай, цаашид хөгжих боломж ихтэй. Эдийн засгийн төрөлжилтийг бий болгох, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, барилга байгууламжийг сайжруулах, орон нутгийн ЖДҮ-ийг хөгжүүлэх шаардлагатай.

Хүн амын суурьшил

ТАНИХ ТЭМДЭГ



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ЯПОНЫ САН




ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШИЛ

Их хот ба хотууд – хүн ам (2020 он)

| | Сумын хүн ам (2020) | Сумын төвийн хүн ам (2020) | | Сумын хүн ам (2020) | Сумын төвийн хүн ам (2020) |
|-----------------|---------------------|----------------------------|-----------|---------------------|----------------------------|
| Даланзадгад | 25 998 | 25 998 | Сэврэй | 2002 | 1032 |
| Баяндалай | 2 079 | 656 | Ханбогд | 8632 | 7200 |
| Баян-Овоо | 1787 | 599 | Ханхонгор | 1992 | 674 |
| Булган | 2093 | 748 | Хүрмэн | 1547 | 630 |
| Гурвантэс | 5041 | 2030 | Цогт-Овоо | 1807 | 817 |
| Мандал-Овоо | 1629 | 677 | Цогтцэций | 7963 | 6800 |
| Манлай | 2586 | 746 | | | |
| Ноён | 1408 | 757 | | | |
| Номгон | 2560 | 706 | | | |
| Өмнөговь | 69 124 | 50 070 | | | |


Шилжилт хөдөлгөөн



Өмнөговь аймаг улсын хэмжээнд хамгийн цөөн хүн амтай аймгуудын нэг. Хүн ам зүйн өсөлт аймгийн төв болон уул уурхайн үйл ажиллагаатай сумдад төвлөрсөн. Статистик мэдээгээр 1990-2020 оны хугацаанд хүн амын шилжин явах хөдөлгөөн


Даланзадгад хот: 28 854 хүн амтай (2020)

Орон зайн тэлэлт




Даланзадгад хотын хүн ам сүүлийн 30 жилд 2 дахин өсөж, 1990 онд 14 мянган хүн амтай байснаас 2021 онд 28 мянга гаруй хүн амтай болжээ. Сүүлийн 15 жилд хот тэлж, баруун урагш, зүүн урагш чиглэлд сунан, хотын төвийн нягтрал нэмэгдэн, олон барилга шинээр баригджээ. Хүн амын өсөлтөөр үндсэндээ гэр хороолол тэлж, хот орон сууцны хөгжлөөр улсын дунджаас доогуур байна. Хотод тулгарч буй томоохон бэрхшээл нь усны дэд бүтэц болон дулаан хангамжийн менежмент.

Орон сууцны хөгжил



Дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ

ТАНИХ ТЭМДЭГ



Эрүүл мэндийн үйлчилгээ

- Нэгдсэн эмнэлэг
- Сум дундын эрүүл мэндийн төв
- Сумын эрүүл мэндийн төв
-

Боловсролын хамгийн дээд түвшин

- Их дээд сургууль
- МСҮТ
- 12 жилийн сургууль
- 9 жилийн сургууль

Зам тээвэр

- Хатуу хучилттай авто зам
- Шороон зам
- Орон нутгийн чанартай нисэх буудал



БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ



Japan
Fund for
Poverty
Reduction

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ЯПОНЫ САН



2022 оны 3 дугаар сар

ДЭД БҮТЭЦ, НИЙТИЙН АЖ АХУЙ

Хот суурины үйлчилгээ: боловсрол ба эрүүл мэнд

Өмнөговь аймгийн эрүүл мэндийн салбар:

- Нэгдсэн эмнэлэг 1, сум дундын эрүүл мэндийн төв 3 (2021 онд шатлалыг бууруулсан)
- Эмнэлгийн орны тоо 669 (1000 хүнд 9,7 эмнэлгийн ор)
- Их эмчийн тоо 197 (1000 хүнд 2,8 их эмч)

Өмнөговь аймгийн хүн амын дундаж наслалт улсын дунджаас бага зэрэг илүү (улсын дунджаар 70,41 жил, Өмнөговь аймгийн дунджаар 72,3 жил).

Боловсролын үйлчилгээ:

- Цэцэрлэг 29
- Бага сургууль 22 (сум бүрт багадаа нэг), ахлах сургууль дөнгөж 6
- МСҮТ 3 (Даланзадгад, Ханбогд, Цогтцэций сумд)
- Их, дээд сургууль байхгүй

Өмнөговь аймгийн хамран сургалтын хувь өндөр (бага сургуулийн хамран сургалт 97,4%, дунд сургуулийн хамран сургалт 97,2%), улсын дундажтай ойролцоо.

Тээвэр

Даланзадгад хот, нийслэл Улаанбаатар хотын хооронд хатуу хучилтай замтай, уурхайнууд нь улсын хилийн 2 боомтоор БНХАУ руу бүтээгдэхүүн экспортолдог. Аймгийн доторх авто замын дийлэнх нь хатуу хучилтгүй шороон зам, хөрш зэргэлдээх аймгууд руу мөн шороон замтай. Өвөрхангай, Баянхонгор аймгууд руу хатуу хучилттай зам байхгүй. Цогтцэций сумаас Ханги хилийн боомт (Дорноговь аймаг) руу уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх хатуу хучилттай авто зам барьж байна.

Өмнөговь аймаг 4 нисэх онгоцны буудалтай. Ханбумбат нисэх онгоцны буудлын хамт нийт 3 нисэх буудал зөвхөн уул уурхайн компаниудад үйлчилж байна. Даланзадгад хотын Гурвансайхан нисэх онгоцны буудал ганцаараа дотоодын бүх зориулалтын нислэгийг хүлээн авч, үйлддэг.

Гол хэдэн уурхайгаас аймгийн гаднах зах зээл рүү төмөр зам барих 3 үндсэн төсөл хэрэгжиж байна: Тавантолгойн уурхайгаас Дорноговь аймаг (Ханги хилийн боомт), мөн (Гашуунсухайт хилийн боомт) БНХАУ-ын чиглэлд 2 (аль аль нь 2022 онд хэрэгжиж дуусах), Нарийнсухайтын нүүрсний уурхайгаас (Шивээхүрэн хилийн боомт) БНХАУ-ын чиглэлд 1 (хэрэгжиж эхлээгүй).

Хот суурины дэд бүтэц ба орон сууц



Өмнөговь аймгийн хотын үндсэн дэд бүтцийн хөгжил, үйлчилгээний хүртээмж улсын дундажтай ойролцоо. Даланзадгад хотын цахилгаан хангамж, ус хангамж, хог хаягдлын менежментийн дэд бүтэц, үйлчилгээ сайн, хамралт холболтын үзүүлэлт өндөр байна.

Өмнөговь аймгийн бусад суманд дэд бүтэц, үйлчилгээний хүртээмж харилцан адилгүй, нутаг дэвсгэрийн тэнцвэрт байдал ихээр алдагджээ. Эрдэс баялгийн арвин нөөцтэй, хот суурины хүн ам ихтэй сумдын дэд бүтэц, үйлчилгээ ерөнхийдөө сайн. Тухайлбал: Гурвантэс, Цогтцэций сумд. Ханбогд, Баяндалай зэрэг сумдын дэд бүтэц, үйлчилгээ сайжрах чигтэй, бусад сумдын хувьд дэд бүтэц, үйлчилгээ хангалтгүй байна.



Эдийн засаг

Уул уурхай

- Эрдэс баялгийн арвин нөөцтэй.
- Аймгийн эдийн засгийн хөгжлийг хөтөлгөчид нь уул уурхайн компаниуд, тэд бусад салбарт хөрөнгө оруулалт хийх орлогыг бүрдүүлдэг (т: “Оюу толгой” ХХК).
- Авто зам, төмөр зам барихаар одоо хэрэгжүүлж буй төслүүд нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг дэмжинэ.
- Уул уурхайн үйл ажиллагаанаас хот байгуулалт, орон нутгийн эдийн засгийн хөгжилд ихээр нөлөөлөх боломжтой

Хөдөө аж ахуй

- МАА: Өмнөговь аймаг тэмээний гаралтай бүтээгдэхүүний өртгийн сүлжээнд өрсөлдөх давуу талтай, сайн чанарын ноолуур бүхий ямаан сүрэгтэй.
- МАА-н өртгийн сүлжээг хөгжүүлэх боломжтой: мөшгөх тогтолцооны QR (шуурхай хариултын) системтэй, бруцеллөз өвчингүй аймгийн гэрчилгээтэй, малын өвчнийг оношлох лабораторитой.
- Орон нутгийн хэрэгцээнд зориулан хүнсний ногооны үйлдвэрлэл хөгжсөн. Аялал жуулчлал
- Байгалийн ба экологийн аялал жуулчлал: улсын хэмжээнд аялал жуулчлалын үндсэн 3 чиглэлийн нэг.
- Аялал жуулчлалын салбар улам хөгжиж буй, хил орчмын аялал жуулчлал хөгжүүлж, БНХАУ-тай хамтран ажиллах боломжтой.
- Аялал жуулчлалын төлөвлөлтийн чадавхаар улсын дунджаас илүү.
- “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” (“Оюу толгой” ХХК) хөрөнгө оруулалтыг санхүүжүүлдэг.

Байгаль орчин

Давуу тал

- Аймгийн нутаг дэвсгэр байгалийн олон янз байдалтай, үүнд өндөр уулс, ой, заримдаг цөлтэй, мөн олон улсад ховордсон зэрлэг амьтадтай, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.
- Улсын тусгай хамгаалалттай газар нутаг ихтэй, эмзэг эко систем бүхий тэдгээр газарт уул уурхайг хөгжүүлэх боломжгүй, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

Боломж

- Уул уурхайн компани байгаль орчинд үзүүлж буй нөлөөллөө бууруулах зарим үүрэг хүлээдэг. Тухайлбал: “Оюу толгой” ХХК “Нутгийн ургамал үржүүлгийн төв” байгуулахад хөрөнгө оруулсан.
- Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх.
- Цөлжилтийг зогсоох үүднээс заг тариалах санаачилга гаргасан.
- Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр “Бэлчээр эрдэнэ Ханбогд” төсөл хэрэгжүүлж буй.
- Байгаль орчны ба агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрүүд (“Эко жорлон”, “Ногоон хэрэм”, “Агаарын бохирдолгүй Өмнөговь”)
- “Хүртээмжтэй хөгжил” төлөвлөгөөний зорилт 5.4-д нийцүүлэн биологийн олон янз байдлыг хамгаалах бодлого хэрэгжүүлэх.
- “Хүртээмжтэй хөгжил” төлөвлөгөөний зорилт 5.5-д нийцүүлэн бэлчээр усжуулах зорилгоор усны тогтвортой менежментийн бодлого (III аян) хэрэгжүүлэх.

Хот, суурин

Давуу тал

- Аймгийн төвөөс гадна, хэд хэдэн жижиг хот суурин, сум дундын төв болон хөгжиж, хөдөөгийн хүн амд үйлчилгээ үзүүлэх боломжтой, үүнд: Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумд.
- АХБ-ны “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжил” төслийн хөрөнгө оруулалт (Гурвантэс, Цогтцэций, Ханбогд), “Жишиг сум” төслийн (Сэврэй сум) үр дүнд эдгээр газрын хот, суурины нөхцөл сайжирсан.
- “Оюу толгой” ХХК (“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”) Ханбогд сумын төвийн хотын дэд бүтэц, нийтийн хэрэгцээний барилга байгууламжид хөрөнгө оруулалт хийсэн.
- Сүүлийн үед хэрэгсэн авто замын төсөл (Даланзадгад-Гурвантэс чиглэлийн 301 км урт замын 150 км замыг барьж буй).

Боломж

- Хотын дэд бүтэц, нийтийн хэрэгцээний барилга байгууламжийн хөгжилд уурхайн компаниуд санхүүжилт олгодог (“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” буюу “Оюу толгой” ХХК жилд сая ам.долларыг орон нутгийн захиргааны төслүүдэд олгодог).
- АХБ-ны “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжил” төслөөс хотын дэд бүтэцэд хөрөнгө оруулсан.
- “Хөх морь” төсөл: “Орхон-Говь” ба “Хэрлэн-Говь” усыг алсад шилжүүлэх төслүүд (судалгааны үе шатанд). Говь+усны хөтөлбөр.
- Бүх сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын ерөнхий төлөвлөгөөг бэлтгэж буй.

Нийгмийн хөгжил

Давуу тал

- 3 МСҮТ-тэй: Даланзадгад, Ханбогд, Цогтцэций сумдад.
- Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бусад уурхайтай харьцуулахад Өмнөговь аймгийн зарим уурхай орон нутгийн ажилчдыг ажилд авдаг, орон нутгийн иргэд уул уурхайн үйл ажиллагааны үр шимийг хүртдэг. Гэхдээ Цогтцэций сумын зарим уурхай (“Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХХК, жижиг Тавантолгойн уурхай г.м.) орон нутгийн иргэдийг ажилд авдаггүй.
- «Говийн оюу хөгжлийг дэмжих сан» тогтмол, сайн үйл ажиллагаа явуулдаг
- Даланзадгад хотын нийтийн тээвэр хөгжиж байна.

Боломж

- Уул уурхайн компаниуд эрүүл мэнд, боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийх.
- НҮБХАС, ДЭМБ-аас хөрөнгө оруулалт хийх.

Эдийн засаг

- Хүн амын нягтрал маш бага
- Хязгаарлагдмал гадаргын усны нөөцтэй: ус ашиглалтын маргаан гардаг (ХАА, уул уурхай, хүний хэрэглээ г.м.)
- Хөдөөгийн олон суманд дэд бүтэц, үйлчилгээ дутагдалтай.
- Аймгийн доторх замын сүлжээ тааруу (сайжирч буй)
- Хөрөнгө оруулалтын хувьд уул уурхай бүхий сумд илүү авдаг, нутаг дэвсгэрийн тэнцвэрт байдал хангагдаагүй.
- Усны нөөц хомстолтой нөхцөл уул уурхайн үйл ажиллагааны тогтвортой байдал хангагдахгүй, мөн бусад үйлдвэрлэл, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.
- Орон нутгийн эдийн засгийн хөгжилд уул уурхайгаас үзүүлэх нөлөө бага: ЖДҮ-ийн чадавх худалдан авалтын шаардлагыг хангахгүй.
- Уул уурхайн сангаар дамжуулан хөрөнгө оруулалт хийх төлөвлөлт, зохицуулалт хангалтгүй.
- Хилийн боомтын хүчин чадал хангалтгүй.
- Эдийн засгийн төрөлжилт, жижиг бизнесийн санхүүжилт дутагдалтай.
- ХАА, аялал жуулчлалын салбарт мэргэжилтэй ажилчдын хөдөлмөр эрхлэлт дутагдалтай.
- ХАА-н бүтээгдэхүүнийг боловсруулах том хэмжээний үйлдвэр дутагдалтай.
- ХАА-н сайн туршлагыг хэрэгжүүлэх малчдын сургалт, урамшуулал дутагдалтай.

Эрсдэл

- Уурхайн ашиглалтын хугацаа тодорхойгүй.
- Ган, цөлжилт, уур амьсгалын өөрчлөлт нь усны нөөцөд нөлөөлөх.
- Газрын тогтцыг эвдэж (уурхай, зам, төмөр зам), амьдралын чанар, аялал жуулчлалд сөргөөр нөлөөлөх.

Байгаль орчин

- Усны нөөцийн хомстолтой: усны нөөц хамгийн багатай аймгуудын нэг. Аймгийн ихэнх хэсэгт усны хомстолтой усны чанарын асуудалтай (хатуулаг).
- Хур тунадас бага ордогос нуур, горхи хатаж ширгэсэн.
- Аянга цахилгаан, үерийн давтамж нэмэгдэж буй.
- Уул уурхай, тээврийн үйл ажиллагаанаас газрын доорх усны чанар, хүн, мал амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, тоосжилт, бэлчээр талхлалт, цөлжилт, газрын доройтол үүсгэж буй.
- Нүүрс тээврийн улмаас тоосжилт, дуу чимээ, агаарын бохирдол бий болсон (Цогтцэций, Ханбогд сумд).
- Үндсэндээ нүүрс тээврийн зориулалтаар барьж буй авто зам, төмөр замын сөрөг нөлөө: бохирдол, зэрлэг амьтдын тархац нутгийг хэсэгчлэн хуваах, зам гарах, дамжин өнгөрөх гарцгүй болгох, нүүдлийн замыг нь таслах.
- Аймгийн төв ба уурхайн орчимд агаарын бохирдол ихэссэн.
- Уул уурхайн олборлолт хийсэн газрын нөхөн сэргээлт хийддэггүй.

Эрсдэл

- Газрын доорх усыг хэт их хэмжээгээр ашиглаж буйгаас нөөц хурдан багасах.
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө улам хурдсаж, ууршилтын хувь нэмэгдэж буйгаас хөрсний үржил шим муудаж, шороон шуурга, элсний хөдөлгөөн ихсэх.
- Монгол Улс, БНХАУ-д шахмал түлшний эрэлт ихсэж, улмаар уул уурхайн үйл ажиллагаа улам нэмэгдэх.
- Уул уурхайн олборлолтын талбай руу барихаар төлөвлөж буй авто зам, төмөр замын улмаас хэд хэдэн зүйлийн тархац нутагт аюул эрсдэл бий болох.

Хот суурин

- Даланзадгад: дунд хэмжээтэй аймгийн төв, дэд бүтцийн ихээхэн хэрэгцээтэй (ус, дулаан, үерийн хамгаалалт).
- Уул уурхай бүхий сумдын хүн ам хурдан өсөж, хот төлөвлөлт хангалттай хийгдэхгүй: орон сууц, дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, нийтийн хэрэгцээний барилга байгууламж дутагдалтай. Гэр хороолол тэлсэн.
- Дэд бүтцийг өргөтгөх шаардлагатай.
- Хүн амын тоонд тоологддоггүй хөдөлгөөнт хүн амын тоо ихэссэн, хот төлөвлөлт хийх хүндрэл үүсгэж буй. Аймгийн хэмжээнд 80 мянга гаруй хөдөлгөөнт хүн ам бий.
- Уул уурхайн хот, суурины хүн амын өсөлтийг даган бий болох усны хэрэгцээг хангах нөөц хангалттай эсэх нь тодорхойгүй.
- Орон зайн хувьд аймгийн төв ба уул уурхай бүхий сумдын орчимд боломж төвлөрч, хөрөнгө оруулалтыг уул уурхай бүхий сумдад түлхүү хийн, нутаг дэвсгэр, мөн үндсэн үйлчилгээний хүртээмжийн хувьд тэгш бус байдал бий болгож буй. Хөдөөд хотын үндсэн дэд бүтэц, үйлчилгээний хүртээмж хангалтгүй (ус, бохир, дулаан).
- Нутаг дэвсгэрийн тэнцвэргүй байдал, уул уурхай бүхий сумдын хүний сонирхлыг татах чадвар зэргээс болж зарим сумын хүн ам шилжин явах, гүн хямралд орох.
- Төлөвлөлт, дэд бүтэц, үйлчилгээгүй, албан бус сууринууд бий болох (Цагаан хад, Морин заг).
- Гурвантэс, Сэврэй сумдын цахилгааны хангамж БНХАУ (Алшаа тойрог)-аас хамааралтай болох.
- Хатуу хучилттай зам дутагдалтай (сайжирч буй).

Эрсдэл

- Уур амьсгалын өөрчлөлт
- Ковид-19 цар тахал
- Орон нутгийн улс төрийн нөхцөл байдал
- Хөрш орнуудын улс төрийн нөхцөл байдал
- Хот суурин газрын үерийн эрсдэл
- ОХУ-аас цахилгааны хараат байдал

Нийгмийн хөгжил

- Хүн амын тоонд тоологдоогүй хөдөлгөөнт хүн ам их, улмаар төлөвлөлт хийх, төрийн үйлчилгээг хүргэхэд хүндрэл үүсгэж буй.
- Сум дундын эрүүл мэндийн төвийн шатлалыг бууруулж сумын эрүүл мэндийн төв болгон, хүн амын тоо өсөж байхад нөөцийн хомстолд оруулсан. ЭМТ-ийн ачаалал хэтэрсний улмаас орон нутгийн иргэддээ эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй болсон.
- Уул уурхайн салбарт ажиллагсад болон бусад салбарт ажиллагсдын орлого зөрүүтэй. Орлого их олох учир уул уурхайн салбарт ажиллах сонирхол ихтэй, улмаар эрүүл мэнд, боловсрол зэрэг бусад салбарт хүний нөөцийн дутагдал үүсгэж буй.
- Найдвартай ус хангамж, ариун цэврийн байгууламж хангалтгүй.
- Цагаан хад, Морин заг албан бус суурьшлын бүсэд амьдралын чанар хангалтгүй (аюулгүй байдал, ариун цэврийн нөхцөл зэрэг хангалтгүй).
- Гэр бүлийн, хүүхдийн эсрэг хүчирхийлэл их гардаг.
- Өсвөр насны жирэмслэлт, хүүхэд тэргүүнтэй өрхийн тоо их.


Эрсдэл

- Уул уурхайн төвүүдийн зориулалтыг өөрчлөн хөгжүүлэх урт хугацааны төлөвлөгөө байхгүй.
- Орон нутгийн хүн амыг татан оролцуулах, орон нутгийн бизнесүүд дутагдалтайн улмаас аялал жуулчлалаас орон нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөө боломжит хэмжээнээсээ бага байх.
- Уул уурхай, зам тээврийн осол аваар их гарах.
- Гурвантэс суманд гар аргаар уурхай эрхэлж буй хүмүүсийн тухайд аюулгүй ажиллагааны асуудал гарах.



Алсын хараа

**Уул уурхайд чиглэсэн аймгийн
эдийн засгийн төрөлжилт, хөгжлийн
тогтвортой байдлыг дэмжих**



ХОТ СУУРИНЫ ТОГТОЛЦОО

Өмнөговь аймгийн хот суурины тогтолцоо нэг үндсэн хот (Даланзадгад), 2 хурдатай хөгжиж буй жижиг хот (Ханбогд, Цогтцэций сумдын төв), хот болон хөгжих боломжтой 1 суурин (Гурвантэс сумын төв), хөдөөгийн 11 сууринаас бүрддэг. Аймгийн эдийн засаг МАА, уул уурхай, үйлдвэрлэлд суурилсан төрөлжсөн. Иймд эдийн засгийн өөр өөр салбар, хоёрдогч төвүүдэд төвлөрөн хөгжүүлж, нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах боломжтой. Даланзадгад хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих үүднээс хотын дэд бүтцэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийх шаардлагатай бол Ханбогд, Цогтцэций сумдын хүн ам өсөж байгаатай уялдуулан, төлөвлөлтийг сайжруулан, хоёрдогч үндсэн хотууд болгон хөгжүүлэх боломжтой.

Аймгийн төв **Даланзадгад хот - 51077** хүн амыг дэд бүтэц, үйлчилгээгээр хангадаг

- Даланзадгад хот динамик сайтай хот бөгөөд эдийн засгийн үндэс нь үйлдвэрлэл, үйлчилгээ. Авто замын харилцаа сайтай (нийслэл Улаанбаатар хот руу хатуу хучилттай авто замтай, олон улсын нисэх онгоцны буудалтай) тул Гурван сайхан уулсыг сонирхож, судлах аялагчид, явган аялагчдын амрах газар болж, аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

- Даланзадгад хотын ус хангамж (3000м³ усан сан), цахилгаан станц (65МВт цахилгааны станцын ТЭЗҮ хийгдсэн), орон сууц (бусад аймгийн төвүүдээс хоцрогдсон), үерийн хамгаалалт (2018 онд томоохон үер болсон), хог хаягдлын менежмент, эрүүл мэндийн барилга байгууламж (50 ортой хүүхдийн эмнэлэг шаардлагатай), нийтийн хэрэгцээний барилга байгууламж (залуучуудын хөгжлийн төв, ахмад настны хөгжлийн төв, сэргээн засах эмнэлэг, соёлын ордон, спорт цогцолбор барих)-ийг сайжруулахад хөрөнгө оруулалт хийх шаардлагатай



Ханбогд сум - Сум дундын төв

- Хүн амын өсөлтийн төсөөлөлтэй уялдуулан хотын дэд бүтцийг барих шаардлагатай. Орон нутгийн үзэж буйгаар ус, дулаан хангамж, цахилгаан станц, үерийн хамгаалалтыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай.
- Стратегийн үндсэн чиг баримжаанд боловсрол, эрүүл мэндийн барилга байгууламж, залуучуудад зориулсан соёлын барилга байгууламж, төрийн албан хаагчид, уул уурхайн бус салбарт ажиллагсдад зориулсан орон сууц, сумын агро-парк тус тус барих гэж заасан.


Цогтцэций сум - Сум дундын төв

- Хүн амын өсөлтийн төсөөлөлтэй уялдуулан хотын дэд бүтцийг барих шаардлагатай. Орон нутгийн үзэж буйгаар үерийн хамгаалалт, хог хаягдлын менежмент, цахилгаан станцыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай.
- Стратегийн үндсэн чиг баримжаанд боловсрол, эрүүл мэндийн барилга байгууламж, төрийн албан хаагчид, уул уурхайн бус салбарт ажиллагсдад зориулсан орон сууц, сумын агро-парк тус тус барих, "Хадан-Ус" суурьшлын бүсэд үндсэн үйлчилгээний төлөвлөлт хийх, үйлчилгээ үзүүлэх гэж заасан.

Гурвантэс - Сум дундын төв

- Гурвантэс суманд авто зам, дэд бүтэц, орон сууц барих, албан бус суурины төлөвлөлт хийх, эдийн засгийн төрөлжилтийг хэрэгжүүлэх (агро-парк, аялал жуулчлал г.м.) замаар сум дундын төв болгон хөгжүүлэх.

Нутаг дэвсгэрийн хөгжлийн хөтөлбөр



ТАНИХ ТЭМДЭГ

Хөдөө аж ахуйн хөгжил

- Газар тариалан эрхэлхэд тэргүүлэх газар
- Бэлчээрийн менежментийн хөтөлбөр хэрэгжүүлэх тэргүүлэх сум
- Тусгай хамгаалалтай газар

Зам тээвэр

- Шинэ хатуу хучилттай авто зам
- Замын сүлжээг сайжруулах
- Төлөвлөгдсөн төмөр зам

Хотын бүтэц

- Аймгийн төв
- Дунд зэрэглэлийн хот
- Хөдөөгийн төв

Даланзадгад

- ХАА, хүнс, МАА-н дайвар бүтээгдэхүүн боловсруулах
- Логистик/Тээврийн төв

Дунд шатны хот сууринг бэхжүүлэх

- Хотын дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ, орон сууцныг сайжруулах
- МАА-н дайвар бүтээгдэхүүн, хүнс, ХАА чиглэлээр Агро-Парк хөгжих
- Усжуулалтын систем
- Аялал жуулчлалын үйлчилгээ

Бусад

- Ашигт малтмалын нөөц

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ЯПОНЫ САН

2022 оны 3 дугаар сар

НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Аймгийн нийгэм-эдийн засаг, нутаг дэвсгэрийн хөгжлийг хангах, иргэдийн амьжиргааг сайжруулах үүднээс дараах төслийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

Нутаг дэвсгэр, хот суурины төлөвлөлт

Аймгийн төв болон хоёрдогч хот, суурин, хилийн боомтын төлөвлөлт хийх, тэдгээрийг хөгжүүлэх. Авто зам, төмөр замын дагуу логиستيкийн төвүүд байгуулах, төлөвлөгдсөн суурин газруудыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

Уул уурхайн салбарын тогтвортой байдлыг хангах стандартыг сайжруулах

Уул уурхайн салбараас орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг сайжруулах үүднээс уул уурхайн салбарын хууль, тогтоомж, институцийн хүрээг бэхжүүлэх. Аймгийн Уул уурхайн сан байгуулж, орон нутгийн бүх уурхайнаас оруулж буй хөрөнгийг төвлөрүүлдэг болохыг санал болгож байна. Уг сангийн хөрөнгөөр уул уурхайн салбарын нийгэм, байгаль орчны хяналтын хороог санхүүжүүлэн ажиллуулахын зэрэгцээ орон нутгийн хөрөнгө оруулалтыг хийдэг болох, үүнд: хот суурины төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, эрүүл мэнд, боловсрол, соёлын барилга байгууламж, хотын дэд бүтэц, эмч, багш нарт зориулсан орон сууц, иргэдийн орлогод нийсэн орон сууц барих. Уул уурхайн компаниуд орон нутгаас худалдан авалт хийх, орон нутгийн ажиллах хүчийг ажилд авах, хөгжлийн төлөвлөгөөгөө нийтэд ил болгох, шинээр хот суурин барихын оронд одоо байгаа хот сууриныг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээх нь зүйтэй.



Усны менежментийн хөтөлбөр

Усны хомстлыг нөхөх үүднээс усыг алсад шилжүүлэх төсөл хэрэгжүүлэх. Өмнөговь аймаг “Хөх морь” хөтөлбөрийн хүрээнд төлөвлөж буй 2 төслөөс үр шим хүртэх боломжтой: “Хэрлэн Тооно”, “Орхон-Онги” усыг дамжуулах цогцолборын төсөл. Усыг алсад шилжүүлэх эдгээр төслийн үндсэн үр шимийг уурхайнууд хүртэнэ. Орон нутгийн нөөцийг бусад үйлдвэрлэлд зориулан хадгалах, хамгаалалтыг тогтвортой менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх нь зүйтэй.


Мал аж ахуйн хөтөлбөр

Уг хөтөлбөрөөр сум бүрд худаг гаргах, бэлчээрийн менежмент хэрэгжүүлэх, малын тоонд хяналт тавих, мал эмнэлгийн үйлчилгээ, зохион байгуулалтын бүтцийг сайжруулах, малчдад зориулсан санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсруулах аж үйлдвэрийн ТЭЗҮ хийх, ХАА-н хоршоог хөгжүүлэх, тоног төхөөрөмжийн хангамжийн сайжруулах зэрэг үйл ажиллагаанд төвлөрнө.

Тогтвортой, хүртээмжтэй аялал жуулчлал

Аялал жуулчлалаас орон нутгийн эдийн засагт үзүүлж буй нөлөөг сайжруулах. Аймгийн МСҮТ-дэд аялал жуулчлал, эко аялал жуулчлалын холбогдох анги, сургалт бий болгох нь зүйтэй. Аялал жуулчлалын үйлчилгээний газар, жуулчны баазуудад орон нутгийн ажиллах хүчийг илүү олноор ажиллуулах, орон нутгийн нийлүүлэгчдээс бүтээгдэхүүн худалдан авдаг болох нь зүйтэй. Бусад үндсэн чиг баримжаанд хүнсний ногооны үйлдвэрлэлээр аймгийн дотоодын хэрэгцээг хангах, бэлчээрийн газрын доройтлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх зэрэг орно.

Архипелаг (Archipelago) тогтолцоо



Барилга, хот байгуулалтын яам | Азийн хөгжлийн банк | Япон Фанд for Poverty Reduction | From the People of Japan

- ### Хотын төрөл
- Хайпер метрополис хот
 - Метрополис хот
 - Хот суурин газар #1 (бүсийн үйлчилгээ үзүүлэх төв)
 - Хот суурин газар #2 (хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэмжих суурин газар)
 - Баянбүрд
 - Хөдөөгийн үйлчилгээний төв #1 (сум дундын төв)
 - Хөдөөгийн үйлчилгээний төв #2 (нийгмийн үйлчилгээний төв)

- ### Нутаг дэвсгэрийн холбоос
- Хөгжлийн коридор
 - Кластер хөгжүүлэлт
 - Тээврийн коридор

groupehuit | MAD URBAN | naomis | IAU

Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр

Аймгийн хөгжлийн чиг баримжаа
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АТЛАС

MAD URBAN | naomis | groupehuit